



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/194/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт	21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	23

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ШУ	Шинжлэх ухаан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил
ДЗОУБ	Дэлхийн зон олон улсын байгууллага



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ц.РЭНЦЭННОРОВ ТАНАА**

2025.02.25 № САА-2025/194/НА-СТР-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35 А/10/, А/09 дүгээр хамтарсан тушаалын 6, 7, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын 3.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

1.Багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй, нэмэгдлийг сар бүр олгодоггүй буюу зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж, дүгнэн нэмэгдэл олгосон.

2.Үйл ажиллагааны орлогыг сүүлийн 3 жилийн дунджаар бус хэт багаар төлөвлөсөн,

432502245

3. Үдийн цай хөтөлбөрийн болон дотуур байрны хүүхдийн ирц, хүнсний материалын зарцуулалтад холбогдох албан тушаалтнуудын зүгээс хяналт тавьдаггүй, хүүхдийн ирцийг бодитоор тооцдоггүйгээс өдөр бүр тогтмол тоогоор тооцож, хүнсний материалыг зарцуулсан, тайлант онд бэлтгэсэн хүнсний материалыг бүгдийг нь зарцуулснаар буюу хүнсний материалын үлдэгдэлгүйгээр тайлагнасан.

4. Холбогдох албан тушаалтнуудын зүгээс хяналт тавиагүй, нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ аваагүйгээс нийт малын 67.4 хувьтай тэнцэх 145 толгой мал зүй бусаар хорогдсоноор бүртгэгдсэн боловч уг хорогдол нь малын эмчийн тогтоосон хорогдлын акт болон бусад баримтуудаар бүрэн нотлогдохгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яам, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Боловсролын газар, ДЗМОУБ, Боловсролын ерөнхий газраас 183,467.4 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, сурагч ширээ, сандал зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	694,898,338.03	705,369,693.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	411,365,167.44	397,884,522.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	411,365,167.44	397,884,522.60
3121	Төгрөг	411,365,167.44	397,884,522.60
31211	Төрийн сангийн харилцах	411,365,167.44	397,884,522.60
33	АВЛАГА	00.00	272,499.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	272,499.80
35	БАРАА МАТЕРИАЛ	283,533,170.59	307,212,670.89
351	Түүхий эд материал	16,587,810.00	20,264,650.00
35110	Тусгай зориулалттай материал	16,374,650.00	20,264,650.00
35130	Эм боох материал	213,160.00	00.00
354	Хангамжийн материал	231,445,360.59	273,308,020.89
35410	Бичиг хэргийн материал	90,000.00	2,940,000.00
35420	Аж ахуйн материал	213,738,644.35	247,666,824.35
35440	Түлш, шатах тослох материал	100,000.00	00.00
35460	Хүнсний материал	4,994,270.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	12,522,446.24	22,701,196.54
35600	Мал амьтад	35,500,000.00	13,640,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,338,406,279.44	5,202,855,902.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,338,406,279.44	5,202,855,902.84
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	4,988,743,529.46	4,855,905,652.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,515,620,938.50	5,545,596,068.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,036,005,662.44	-1,269,133,607.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,090,500.00	21,090,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,090,500.00	-21,090,500.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	658,413,285.09	793,644,806.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-320,681,276.36	-424,819,648.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	301,121,812.85	376,970,626.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-155,902,013.02	-196,664,180.20
39217	Ном	26,176,444.84	30,311,588.14
393	Биет бус хөрөнгө	349,662,749.98	346,950,249.94
39301	Програм хангамж	15,085,000.00	15,085,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-12,246,250.02	-14,958,750.06
39303	Бусад биет бус хөрөнгө	348,959,000.00	348,959,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,135,000.00	-2,135,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,033,304,617.47	5,908,225,596.13
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	982,800.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	982,800.00	00.00
413	Өглөг	982,800.00	00.00
4136	Бусад өглөг	982,800.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	982,800.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,032,321,817.47	6,032,321,817.47
51	Засгийн газрын хувь оролцоо	6,032,321,817.47	6,032,321,817.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,128,048,996.21	2,128,048,996.21
51101	Өмч: - төрийн	2,128,048,996.21	2,128,048,996.21
512	Хуримтлагдсан үр дүн	59,933,924.33	59,933,924.33
51210	Өмнөх үеийн үр дүн	59,933,924.33	59,933,924.33

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-124,096,221.34
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,844,338,896.93	3,844,338,896.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,033,304,617.47	5,908,225,596.13

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,344,878,711.89	4,313,816,446.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	947,327,378.14	285,433,607.16
120	Нийтлэг татварын бус орлого	947,327,378.14	285,433,607.16
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,204,848.00	73,061,916.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,037,648.00	6,969,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,167,200.00	66,092,516.07
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	78,662,150.14	28,904,282.84
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	815,460,380.00	183,467,408.25
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,397,551,333.75	4,028,382,839.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,006,304,100.00	3,622,382,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,006,304,100.00	3,622,382,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	391,247,233.75	405,999,939.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	391,247,233.75	405,999,939.50
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,337,158,695.96	4,415,601,202.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,337,158,695.96	4,415,601,202.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,178,635,720.96	4,252,484,362.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,045,650,443.63	2,862,385,945.76
210101	Үндсэн цалин	1,375,212,519.03	1,731,550,573.29
210102	Нэмэгдэл	590,599,745.96	915,511,448.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	94,162,313.95
210104	Урамшуулал	79,838,178.64	121,161,610.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,874,709.54	341,352,334.12
210201	Тэтгэврийн даатгал	178,356,543.51	233,819,146.75
210202	Тэтгэмжийн даатгал	21,012,277.87	28,846,417.54
210203	ҮОМШО-ний даатгал	16,429,023.03	14,964,978.71
210204	Ажилгүйдлийн даатгал	3,634,661.06	12,837,227.47
210205	Эрүүл мэндийн даатгал	36,442,204.07	50,884,563.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	369,747,233.75	381,999,939.50
210301	Гэрэл, цахилгаан	34,337,108.95	26,294,053.50
210302	Түлш, халаалт	203,168,718.80	223,848,930.00
210303	Цэвэр, бохир ус	132,241,406.00	131,856,956.00
2105	Нормативт зардал	68,257,616.00	82,777,820.00
210502	Хоол, хүнс	68,257,616.00	82,777,820.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,500,000.00	24,000,000.00
210604	Урсгал засвар	21,500,000.00	24,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,349,181.05	40,223,497.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,396,600.00	6,259,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,952,581.05	33,963,597.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	396,256,536.99	519,744,826.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,196,191.00	103,153,941.24

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,888,533.09	31,910,200.00
210903	Үндэс н хөрөнгийн элэгдэл, хорогдол	313,171,812.90	384,680,684.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	158,522,975.00	163,116,840.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	158,522,975.00	163,116,840.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	137,253,475.00	145,913,440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,269,500.00	17,203,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,007,720,015.93	-101,784,756.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,048,052.75	22,311,465.30
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,048,052.75	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	22,311,465.30
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-10,048,052.75	-22,311,465.30
5	НИЙТ ҮР ДҮН	997,671,963.18	-124,096,221.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,450,756,181.75	4,101,444,755.57
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,204,848.00	73,061,916.07
120	Нийтлэг татварын бус орлого	53,204,848.00	73,061,916.07
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	53,204,848.00	73,061,916.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,037,648.00	6,969,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,167,200.00	66,092,516.07
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,397,551,333.75	4,028,382,839.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,006,304,100.00	3,622,382,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,006,304,100.00	3,622,382,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	391,247,233.75	405,999,939.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	391,247,233.75	405,999,939.50
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,019,319,050.97	4,049,262,500.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,019,319,050.97	4,049,262,500.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,857,705,925.97	3,889,796,810.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,045,650,443.63	2,861,284,955.57
210101	Үндсэн цалин	1,365,018,279.24	1,731,823,073.09
210102	Нэмэгдэл	592,890,714.39	914,137,958.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	94,162,313.95
210104	Урамшуулал	87,741,450.00	121,161,610.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	255,874,709.54	342,725,824.11
210201	Тэтгэврийн даатгал	178,356,543.51	232,629,504.78
210202	Тэтгэмжийн даатгал	21,012,277.87	28,446,629.06
210203	ҮОМШО-ний даатгал	16,429,023.03	14,771,581.72
210204	Ажилгүйдлийн даатгал	3,634,661.06	12,837,227.47
210205	Эрүүл мэндийн даатгал	36,442,204.07	54,040,881.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	369,747,233.75	381,999,939.50
210301	Гэрэл, цахилгаан	34,337,108.95	26,294,053.50
210302	Түлш, халаалт	203,168,718.80	223,848,930.00
210303	Цэвэр, бохир ус	132,241,406.00	131,856,956.00
2105	Нормативт зардал	66,986,736.00	78,846,700.00
210502	Хоол, хүнс	66,986,736.00	78,846,700.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,500,000.00	24,000,000.00
210604	Урсгал засвар	21,500,000.00	24,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,349,181.05	69,684,497.23
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,396,600.00	6,259,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,952,581.05	63,424,597.23
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,597,622.00	131,254,894.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,056,000.00	99,344,694.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,541,622.00	31,910,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,613,125.00	159,465,690.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	161,613,125.00	159,465,690.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	140,343,625.00	142,262,290.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,269,500.00	17,203,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	431,437,130.78	52,182,255.16
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	85,792,700.00	65,662,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	85,792,700.00	65,662,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	85,792,700.00	65,662,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	85,792,700.00	65,662,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-85,792,700.00	-65,662,900.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	345,644,430.78	-13,480,644.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	65,720,736.66	411,365,167.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	411,365,167.44	397,884,522.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	-937,738,038.85	5,034,649,854.29
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	-937,738,038.85	5,034,649,854.29
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	997,671,963.18	997,671,963.18
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	59,933,924.33	6,032,321,817.47
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	59,933,924.33	6,032,321,817.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	59,933,924.33	6,032,321,817.47
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-124,096,221.34	-124,096,221.34
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,128,048,996.21	3,844,338,896.93	-64,162,297.01	5,908,225,596.13

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,516,328,600.00	4,114,925,400.41	401,403,199.59	91.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,516,328,600.00	4,114,925,400.41	401,403,199.59	91.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,341,310,000.00	3,955,459,710.41	385,850,289.59	91.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,107,839,200.00	2,861,284,955.57	246,554,244.43	92.1
210101	Үндсэн цалин	2,017,953,500.00	1,731,823,073.09	286,130,426.91	85.8
210102	Нэмэгдэл	1,000,359,400.00	914,137,958.53	86,221,441.47	91.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	94,162,313.95	-94,162,313.95	-
210104	Урамшуулал	89,526,300.00	121,161,610.00	-31,635,310.00	135.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	388,479,900.00	342,725,824.11	45,754,075.89	88.2
210201	Тэтгэврийн даатгал	264,166,300.00	232,629,504.78	31,536,795.22	88.1
210202	Тэтгэмжийн	31,078,400.00	28,446,629.06	2,631,770.94	91.5
210203	даатгал ҮОМШӨ-ний	15,539,200.00	14,771,581.72	767,618.28	95.1
210204	Ажилгүйдлийн даатгал	15,539,200.00	12,837,227.47	2,701,972.53	82.6
210205	мэндийн даатгал Эрүүл	62,156,800.00	54,040,881.08	8,115,918.92	86.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	382,000,000.00	381,999,939.50	60.50	100.0
210301	Гэрэл цахилгаан	40,000,000.00	26,294,053.50	13,705,946.50	65.7
210302	Түлш халаалт	207,000,000.00	223,848,930.00	-16,848,930.00	108.1
210303	Цэвэр бохир ус	135,000,000.00	131,856,956.00	3,143,044.00	97.7
2105	Нормативт зардал	110,299,200.00	78,846,700.00	31,452,500.00	71.5
210502	Хоол, хүнс	110,299,200.00	78,846,700.00	31,452,500.00	71.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,000,000.00	24,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	24,000,000.00	24,000,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	84,773,000.00	69,684,497.23	15,088,502.77	82.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,269,400.00	6,259,900.00	9,500.00	99.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	78,503,600.00	63,424,597.23	15,079,002.77	80.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	243,918,700.00	196,917,794.00	47,000,906.00	80.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	212,008,500.00	165,007,594.00	47,000,906.00	77.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,910,200.00	31,910,200.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	175,018,600.00	159,465,690.00	15,552,910.00	91.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	157,815,200.00	142,262,290.00	15,552,910.00	90.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,203,400.00	17,203,400.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,516,328,600.00	4,101,444,755.57	414,883,844.43	91.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,622,382,900.00	3,622,382,900.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,622,382,900.00	3,622,382,900.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	406,000,000.00	405,999,939.50	60.50	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	406,000,000.00	405,999,939.50	60.50	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	487,945,700.0	73,061,916.07	414,883,789.93	15.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	31,269,400.00	6,969,400.00	24,300,000.00	22.3

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49,720,700.00	66,092,516.07	-16,371,516.07	132.9
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	406,955,600.00	0.00	406,955,600.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		411,365,167.44	-411,365,167.44	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		397,884,522.60	-397,884,522.60	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан	4	4	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	116	109	7.00	94.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	1,453.00	1,453.00		100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь “Хамтаараа хөгжсөн зөв дадал хэвшилтэй хүүхэд болгон төлөвшүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурч, хөгжих хүнлэг энэрэнгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, зэрэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.
- Ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулж, сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх.
- Цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, сурагчдыг чадваржуулах.
- Сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцоо, хамгааллыг хангах.
- Багшийн хөгжил, манлайлал, цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах.
- Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдлөг болгон хэрэгжүүлдэг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт

байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 125,079.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
31	Мөнгөн хөрөнгө	411,365.1	397,884.5	-13,480.6
33	Авлага	00.00	272.4	272.4
35	Бараа материал	283,533.1	307,212.6	23,679.5
39	Үндсэн хөрөнгө	5,338,406.2	5,202,855.9	-135,550.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,033,304.6	5,908,225.5	-125,079.0
4	Нийт өр төлбөр	982.8	0.00	-982.8
51	Засгийн газрын хувь оролцоо	6,032,321.8	5,908,225.5	-124,096.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,033,304.6	5,908,225.5	-125,079.0

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө данс 397,884.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хэмнэлттэй холбоотой,
- Бараа материал дансны үлдэгдэл 307,212.6 мянган төгрөг болж 23,679.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 352,619.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Боловсролын ерөнхий газар, аймгийн Боловсролын газраас нийт 10,226.7 мянган төгрөгийн сурах бичиг, бусад бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 325,285.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,202,855.9 мянган төгрөг болж 135,550.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 65,662.9 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар спортын талбайн тохижилтод 29,975.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 29,850.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Дэлхийн зөн монгол ОУБ-аас 1,399.2 мянган төгрөгийн өнгөт принтер, тоног төхөөрөмж, Боловсролын ерөнхий газраас нөхөн хангалтаар 83,181.4 мянган төгрөгийн техник хэрэгсэл, зөөврийн компьютер, аймгийн Боловсролын газраас 39,001.5 мянган төгрөгийн ухаалаг зурагт, ном, машин, тоног төхөөрөмж, зэрэг нийт 183,407.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 90 дугаар тогтоолоор 3,939.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан, тайлант онд 384,680.7 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан зэргээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,529,619.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Тайлант онд төсөвт зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 3,622,382.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 406,000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 31,269.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 49,720.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 406,955.6 мянган төгрөг, **НИЙТ 4,516,328.6 мянган төгрөгөөр баталсан байна.**

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 3,622,382,9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 405,999.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,969.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 66,092.5 мянган төгрөг зэрэг нийт 4,101,444.7 мянган төгрөг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 4,114,925.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,114,925.4 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 254,447.5 мянган төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээний зардлыг 69,899.3 мянган төгрөгөөр, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах зардлыг 29,619.6 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 15,552.9 төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	7,940.10	7,939.99	0.11	100.0
2	80233 - Хүүхэд хамгаалал	8,154.60	5,389.10	2,765.50	66.1
3	80312 - Сургалт семинар	6,741.70	6,741.60	0.10	100.0
4	81605 - Эрүүл мэндийг дэмжих	13,196.10	13,196.10	0.00	100.0
5	81801 -үдийн цай хөтөлбөр	157,815.20	142,262.29	15,552.91	90.1
6	81806 -Дотуур байрны үйлчилгээ	260,459.40	190,560.61	69,899.30	73.2
7	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	60,411.80	52,036.90	8,374.90	86.1

8	81823-Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	23,829.80	14,704.00	9,125.80	61.7
9	81834-Боловсролын стандарт, сургалтын	3,341,946.90	3,087,499.37	254,447.53	92.4
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	122,168.10	118,746.70	3,421.40	97.2
11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	85,056.20	55,436.64	29,619.56	65.2
12	81848-Сурах бичгийн түрээс	6,269.40	6,259.90	9.50	99.8
13	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	14,690.00	7,593.80	7,096.20	51.7
14	83602-ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	403.00		403.00	-
15	83603-Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	1,246.3	558.45	687.85	44.81
Дүн		4,110,328.6	3,708,925.5	401,403.1	90.23
16	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	406,000.00	405,999.9	0.05	100.0
Нийт		4,516,328.6	4,114,925.4	401,403.2	91.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай, дотуур байрны хоол, хүнс худалдан авах 215,602.7 мянган төгрөгийн тендерийн урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул “Алтан тариа” ХХК, “Алтан есүй” ХХК, “Ирвэсийн хавцал” ХХК, “Сэлэнгэ баян уул” ХХК, Сэлэнгэ титан, Сэлэнгэ ханхүү, Солоон энх түншлэл ХХК, “Цахим ертөнц” ХХК-иуд болон иргэн М.Мөнхцэцэг, Ц.Цэсэм, Д.Даваасүрэн, Л.Энхчимэг С.Энхтайван, Д.Оюунчимэг нартай шууд гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах зөвлөмж өгсөн болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа, чанарын хяналтыг захирал Д.Ариунаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,337,158.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 50,057.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 167 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүй улмаас өр төлбөр үүсгэсэн зөрчил илэрч албан шаардлага өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	982.8	1	982.8	100.0
Нийт дүн	1	982.8	1	982.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, хөтлөлттэй холбоотой алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **41,607.5** мянган төгрөгийн 5 зөрчил¹ илэрч, 4 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

1. Багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй, нэмэгдлийг сар бүр олгодоггүй буюу зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж, дүгнэн нэмэгдэл олгож байна. Тухайлбал захирлын 2024 оны Б/163 дугаар тушаалаар оны шилдэг багш гэх үндэслэлээр 12 дугаар сард нийт 24 багшид тус бүр 10.0-20.0 хувиар тооцон 4,620.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна. Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/, А/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 6-д “Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно”, 7-д “Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу хагас жил тутам шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэж, батлагдсан төсөвт багтаан нэмэгдлийг сар бүр олгож байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тус сургууль нь 2021 онд 44,943.5 мянган төгрөгийн, 2022 онд 29,330.4 мянган төгрөгийн, 2023 онд 40,167.2 мянган төгрөгийн буюу дунджаар **38,147.0** мянган төгрөгийн өөрийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн атал 2024 оны өөрийн орлогыг нэмэгдүүлэлгүйгээр 20,584.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 66,092.5 мянган төгрөг төвлөрүүлэн, төлөвлөгөөнөөс давсан 45,508.5 мянган төгрөгийг зарцуулах эрх авч, зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь “Энэ журмын 3.1.1-т заасан орлого /төлөвлөгөөнөөс давж биелсэн орлого/ -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Үйл ажиллагааны орлогыг сүүлийн 3 жилийн гүйцэтгэл, үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Үдийн цай хөтөлбөрийн болон дотуур байрны хүүхдийн ирц, хүнсний материалын зарцуулалтад холбогдох албан тушаалтнуудын зүгээс хяналт тавьдаггүй, хүүхдийн ирцийг бодитоор бус өдөр бүр тогтмол тоогоор тооцож, хүнсний материалыг зарцуулан, тайлант онд бэлтгэсэн нийт 1,764.5 мянган төгрөгийн хүнсний материалыг бүгдийг нь зарцуулснаар буюу хүнсний материалын үлдэгдэлгүйгээр тайлагнасан байна. Тухайлбал, аудитын явцад тайлант оны 11,12 саруудын үдийн хоол, дотуур байрны ирцийг хоолны өдөрлөгийн ирцтэй тулган баталгаажуулж, түүвэрлэж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Үдийн хоолны өдөрлөгөөр 11 сарын нийт 19 өдрөөс 2 өдөр тус бүр 590, 7 өдөр тус бүр 580, 9 өдөр тус бүр 570, 1 өдөр 578 хүүхдийн ирцээр, 12 сарын 19 өдрөөс 2 өдөр тус бүр 590, 3 өдөр 560, 4 өдөр 580, 5 өдөр 500, 5 өдөр 367 хүүхдийн ирцээр хүнсний материал зарцуулсан байна. / Зөвхөн 12 сарын 8 өдөрт бодит ирцээр 3474 хүүхэд бүртгэгдсэн бол өдөрлөгөөр 3627 хүүхэд бүртгэж, 229.5 мянган төгрөгийн хүнс илүү зарлагдсан байна /
- Дотуур байрны хүүхдийн хоолны өдөрлөгийг 11 амралын өдрөөс бусад 20 өдрийн 18 өдрийг тус бүр 65 хүүхдээр, 2 өдрийг тус бүр 64 хүүхдээр, нийт 1298 хүүхдээр тооцон хүнс зарлагдсан бол жижүүр багшийн ирцээр 20 өдөрт 1131 хүүхэд бүртгэгдсэн, 12 сарын 20 өдрөөс 19 өдрийг тус бүр 65 хүүхдээр, 1 өдрийг 69 хүүхдээр, нийт 1300 хүүхдээр тооцон зарлагдсан бол жижүүр багшийн ирцийн бүртгэлээр уг 20 өдөрт 1083 хүүхэд бүртгэгдсэн байна. /дунджаар хоолны нормативыг 4.0 мянган төгрөгөөр тоцоход 11 сард 667.0 мянган төгрөгийн, 12 сард 868.0 мянган төгрөгийн хүнс илүү зарлагдсан /

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үдийн хоол, дотуур байрны хүүхдийн ирцийг бодитоор тооцон хүнсний материалыг зарцуулах, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх.

4. Холбогдох албан тушаалтнуудын зүгээс хяналт тавиагүй, нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ аваагүйгээс нийт малын 67.4 хувьтай тэнцэх 17,660.0 төгрөгийн үнэ бүхий 145 толгой мал зүй бусаар хорогдсоноор бүртгэгдсэн боловч уг хорогдол нь малын эмчийн тогтоосон хорогдлын акт болон бусад баримтуудаар бүрэн нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “ Анхан шатны баримтын

бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэх, бүртгэл тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Малын тоо толгой, зарцуулалт, хорогдолд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны хүчин төгөлдөр баримтыг үндэслэн малын хорогдлыг хүлээн зөвшөөрч, бүртгэж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал:

Илрүүлэлт: Зайлшгүй шаардлагын улмаас жижүүрүүдээр жолооч, мужаан зэрэг ажил үүргийг хавсруулан гүйцэтгэсэн гэх үндэслэлээр албан тушаалын цалингийн 30-40 хувиар тооцон хавсран ажилласны нэмэгдэл цалин олгохоор шийдвэрлэж, хэрэгжүүлж байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмыг хэрэгжүүлж, төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 138/АМ50385

Сүхбаатар

СА-2025/194/НА-СА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Холбогдох албан тушаалтнуудын зүгээс хяналт тавиагүй, нөхцөл байдалд тохирсон арга хэмжээ аваагүйгээс нийт малын 67.4 хувьтай тэнцэх 17,660.0 төгрөгийн үнэ бүхий 145 толгой мал зүй бусаар хорогдсоноор бүртгэгдсэн боловч уг хорогдол нь малын эмчийн тогтоосон хорогдлын акт болон бусад баримтуудаар бүрэн нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дахь “ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэх, бүртгэл тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.Үүнд: 4.2.1.11: “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мал амьтны тоо толгой, ашиглалт, хорогдолд хяналт тавиагүй, нөхцөл байдлыг үнэлж, тохирох арга хэмжээ аваагүй, хүчин төгөлдөр анхан шатны баримтгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэсэн зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн захирал Ц.Рэнцэнноров, нягтлан бодогч Ж.Бэрцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504413



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 139/АИ850385

Сүхбаатар

00А-2025/194/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Үдийн цай хөтөлбөрийн болон дотуур байрны хүүхдийн ирц, хүнсний материалын зарцуулалтад холбогдох албан тушаалтнуудын зүгээс хяналт тавьдаггүй, хүүхдийн ирцийг бодитоор тооцдоггүйгээс өдөр бүр тогтмол тоогоор тооцож, 1,764.5 мянган төгрөгийн хүнсний материалыг илүү зарцуулсан, тайлант онд хүнсний материалыг үлдэгдэлгүйгээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.Үүнд: " 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн захирал Ц.Рэнцэнноров, нягтлан бодогч Ж.Бэрцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432504413



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 140/А1850385

Сүхбаатар

00А-2025/194/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнээгүй, нэмэгдлийг сар бүр олголгүйгээр зөвхөн 12 дугаар сард нийт 24 багшид тус бүр 10.0-20.0 хувиар тооцон 4,620.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 6-д “Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно”, 7-д “Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ” 4.2.1.11: “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Багш, ажилтнуудын ур чадварыг журмын дагуу хагас бүтэн жилээр үнэлж, дүгнээгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн захирал Ц.Рэнцэнноров, нягтлан бодогч Ж.Бэрцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨРСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432504421



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 152/А/250385

Сүхбаатар

ЦАА-2025/194/НА-ЦА-ТШБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар үйл ажиллагааны орлогыг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн бодитоор нэмэгдүүлж, төлөвлөөгүй 17,563.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь "Энэ журмын 3.1.1-т заасан орлогын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон...үндсэн үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан төсвийн захирагчийн жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.Үүнд: " 4.2.1.11: "Хууль тогтоомж, ... зөрчсөн ..." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогын төлөвлөгөөг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн бодитоор төлөвлөөгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн захирал Ц.Рэнцэнноров, нягтлан бодогч Ж.Бэрцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504454

